



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/534

Номгон

**Зам байгууламж, хөдөлгөөн зохицуулах
техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд
үзлэг шалгалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зам, замын байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалтыг 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс 09 дүгээр сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Зам байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Батхуяг (Замын Цагдаагийн тасийн дарга, цагдаагийн хошууч)

Гишүүд: А.Дорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Зам тээврийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Д.Магвансүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга)

П.Баатар (Баянхонгор сумын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ж.Цогтбаяр (Баянхонгор хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын менежер)

Ц.Батцолмон (Их богд зам ХХК-ийн ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга: А.Эрдэнэбал (Замын цагдаагийн тасгийн Зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч)

3. Үзлэг шалгалтыг зохион байгуулж ажлын үр дүнг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор танилцуулах, холбогдох материалыг архивт журмын дагуу шилжүүлэхийг ажлын хэсгийн ахлагч Замын Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч (А.Батхуяг)-д үүрэг болгосугай.

601210245

2.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

